

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Элэг бүтэн Төв аймагчууд”  
хөтөлбөрийн хэрэгжилт

АУДИТЫН КОД : ТӨА-2021/110-18-ШТА-ГА

Зуунмод 2021 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал  
Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)  
Аудитын менежер О.Амаржаргал  
Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)  
Ахлах аудитор Л.Жаргалсайхан  
Утас: 70273465 Цахим хаяг: [jargalsaikhanl@audit.gov.mn](mailto:jargalsaikhanl@audit.gov.mn)  
Аудитор Ч.Загдсүрэн, Г.Сугармаа  
Утас: 70272287 Цахим хаяг: [zagdsurench@audit.gov.mn](mailto:zagdsurench@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## АГУУЛГА

|                                                                                                                                                                                                                                                                                               |       |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|
| Товчилсон үгийн тайлбар.....                                                                                                                                                                                                                                                                  | 3     |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл.....                                                                                                                                                                                                                    | 4-5   |
| <b>БҮЛЭГ 1. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, “Элэг бүтэн Төв аймагчууд” аймгийн хөтөлбөрүүдэд хэрэгжих боломжтой зорилт, арга хэмжээнүүд тусгагдсан байна.....</b>                                                                                                                      |       |
| 1.1 “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийг зайлшгүй хэрэгцээ шаардлагад үндэслэж боловсруулсан байна.....                                                                                                                                                                                     | 6-7   |
| 1.2 “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийг Аймаг хөгжүүлэх хэтийн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан боловч 2018, 2019 оны аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаагүй байна.....                                                           | 7     |
| 1.3 Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь орон нутагт хэрэгжих боломжтой байна.....                                                                                                                                | 8     |
| <b>БҮЛЭГ 2. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, “Элэг бүтэн Төв аймагчууд” аймгийн хөтөлбөр хэрэгжсэнээр хүн амыг гепатитийн В,С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулах ажил хийгдэж тодорхой үр дүнд хүрсэн байна.....</b>                                                       |       |
| 2.1 Хөтөлбөрийн хүрээнд илрүүлэг, оношилгоо, эмчилгээнд хамруулсан иргэдийн мэдээлэл, судалгаа, сан байхгүй хийгдсэн ажилд дүн шинжилгээ хийх боломжгүй байна.....                                                                                                                            | 8-9   |
| 2.2 Хөтөлбөрийн хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, оношлуураар хангагдсан байна.....                                                                                                                                                                                                       | 9     |
| 2.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн байна.....                                                                                                                                                                                                     | 9-10  |
| 2.4 Урьдчилан сэргийлэх, дархлаажуулах ажил хийгдсэн байна.....                                                                                                                                                                                                                               | 10-12 |
| 2.5 Халдварын эрт илрүүлэх шинжилгээнд иргэдийг хамруулах ажил төлөвлөсний дагуу хэрэгжсэн байна.....                                                                                                                                                                                         | 12    |
| 2.6 Элэгний С вирустэй иргэдийн 40 хувийг эмчилгээнд хамруулах зорилт тавьсан боловч 30.81 хувь нь эмчилгээнд хамрагдсан байна.....                                                                                                                                                           | 12    |
| 2.7 Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр гаргаж байгаа боловч элэгний хорт хавдар, хатуурлаар өвчлөгсдийн тоо болон нас баралтын талаарх тоон мэдээлэл тусгаагдаагүй байна.....                                                                                        | 13    |
| 2.8. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зарим зорилт арга хэмжээ нь хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хангасан байна.....                                                                                                                                        | 13-14 |
| <b>БҮЛЭГ 3. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, “Элэг бүтэн Төв аймагчууд” аймгийн хөтөлбөр нь 2017-2020 онд хэрэгжиж дууссан, хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж үнэлэлт, дүгнэлт өгөх ажил хийгдээгүй байна.....</b> |       |
| 3.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг ИТХ-н Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажилласан байна.....                                                                                                                                                                         | 15-16 |
| 3.2 Хөтөлбөр хэрэгжсэн дөрвөн жилийн хугацаанд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.....                                                                                                                                                                                    | 16-17 |
| ДҮГНЭЛТ:.....                                                                                                                                                                                                                                                                                 | 17    |
| ЗӨВЛӨМЖ:.....                                                                                                                                                                                                                                                                                 | 18    |
| Холбогдох байгууллагын санал:.....                                                                                                                                                                                                                                                            | 19    |

Товчилсон үгийн тайлбар

|        |                                                  |
|--------|--------------------------------------------------|
| МУ     | Монгол улсын                                     |
| ЗГ     | Засгийн газар                                    |
| ЗД     | Засаг дарга                                      |
| ИТХТ   | Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид       |
| ЭМГ    | Эрүүл мэндийн газар                              |
| ЭМХТ   | Эрүүл мэндийн хөгжлийн төв                       |
| ЗДТГ   | Засаг даргын тамгын газар                        |
| ЭМТ    | Эрүүл мэндийн төв                                |
| ЕБС    | Ерөнхий боловсролын сургууль                     |
| ДУС    | Дотоод удирдлагын систем                         |
| ЭМД    | Эрүүл мэндийн даатгал                            |
| МХГ    | Мэргэжлийн хяналтын газар                        |
| ХШУДАХ | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс |

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.**

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын захиалгаар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

**Аудитын зорилт**

“Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит хийж, дүнг аймгийн ИТХ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. /Асуудлын шинжилгээг хавсралт 2-т үзүүлэв/

Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Хөтөлбөрөөр батлагдсан зорилт, арга хэмжээ нь хэрэгжих боломжтой эсэх
- Хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг дүгнэсэн эсэх

**Аудитын хамарсан хүрээ**

“Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах аймгийн Засаг дарга болон Нийгмийн бодлогын хэлтэс, аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн байгууллагууд, аймгийн Эрүүл мэндийн даатгалын газар болон бусад оролцогч байгууллагын үйл ажиллагааг хамрууллаа. Байхгүй.

**Аудитын хязгаарлалт**

**Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгадагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, байгууллагын худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийж асуулга лавлагаа авлаа.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль
- МУ-ын ЗГ-ийн 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 112 дугаар тогтоол,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 05 дугаар

сарын 12-ны өдрийн "Журам батлах тухай" А/94, А/193 дугаар тушаал

- "Аймаг хөгжүүлэх хэтийн чиглэл" /2017-2024/,
- Аймгийн ЗД-ын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- Жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
- Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 09 дүгээр сарын 15-ны "Элэг бүтэн Төв аймагчууд" хөтөлбөр батлах тухай" 22 тоот тогтоол,
- Аймгийн ЗД-ын 2016 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн "Элэг бүтэн Төв аймагчууд" хөтөлбөрийн ажлын хэсэг, үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай А/580 дугаар захирамж,
- Бусад холбогдох хууль тогтоомж, аймгийн ЗД-ын захирамж, ЭМГ-ын даргын тушаалууд

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Ч.Загдсүрэн, Г.Сугармаа нар гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2021 оны 6 дугаар сарын 2-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдөр хийж гүйцэтгэн аймгийн ИТХ-д хүргүүллээ.

**Хүндрэл бэрхшээл**

Улсын онцгой комисс, аймгийн онцгой комиссын шийдвэрээр хөл хорионы дэглэмтэй байгаа тул сум орон нутагт газар дээр нь очиж шалгах, бусад нотлох баримтаар баримтжуулах боломжгүй байв. Мөн аудитад хамрагдагч төрийн байгууллагуудын албан хаагчид ээлжээр, гэрээр ажиллах, ковид-19 өвчнөөр өвчлөх, гэрийн ажиглалт, тусгаарлалтад орох зэргээс шалтгаалан шаардсан баримт материал, судалгаа мэдээлэл авахад цаг алдах зэрэг хүндрэл бэрхшээлтэй байлаа.

**БҮЛЭГ 1. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, “Элэг бүтэн Төв аймагчууд” аймгийн хөтөлбөрүүдэд хэрэгжих боломжтой зорилт, арга хэмжээнүүд тусгагдсан байна**

**1.1. “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийг зайлшгүй хэрэгцээ шаардлагад үндэслэж боловсруулсан байна.**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 22 тоот тогтоолоор “Элэг бүтэн Төв аймагчууд хөтөлбөр”-ийг баталсан байна.

Хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх зорилго, хэрэгцээ шаардлага зайлшгүй байсан нь дээрх тогтоолын хавсралтын ерөнхий мэдээлэлд тодорхой тусгагдсан байна. Үүнээс аймгийн хэмжээнд хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага нь:

- Монгол улсад элэгний хавдрын нас баралтаар /зуун мянган хүн тутам дахь/ дэлхийд тэргүүлж, дэлхийн дунджаас найм дахин их байна.
- 400.0 мянган хүн хепатитийн вирусийн халдвартай байгаагаас болж элэгний хорт хавдар, нас баралтын тоо улам бүр өсөж байна.
- 2015 оны байдлаар хавдрын шалтгаант нас баралт 3999 тохиолдол бүртгэгдсэний 1568 тохиолдол буюу 39.2 хувь нь элэгний хорт хавдар байна
- Төв аймгийн 90.0 мянга орчим хүн амаас 14.0 орчим мянган хүн вирусийн архаг халдвартай, өвчлөл өндөртэй гэсэн судалгаа гарсан.

Аймгийн хэмжээнд 30-с дээш насны 40.0 мянга орчим хүнийг хепатитийн вирусийн архаг халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулж, халдвартай хүмүүсийг хяналтад авч, эмчилгээ хийх, халдвар авахаас сэргийлэх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулах зайлшгүй шаардлага бий болсон байна.

Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт ихсэж байгаатай холбоотойгоор хепатитийн вирусийн голомтыг устгах, элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулах зорилготой “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг эмч, судлаачид өвчтөний төлөөллөөс бүрдсэн баг санаачлан, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлж эмчлэх ажлыг орон даяар эхлүүлсэн байна. Төв аймагт элэгний С вирусийн голомтыг 2020 он гэхэд устгаж, элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулна гэсэн зорилго, зорилт тавьж энэхүү хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлжээ.

Хөтөлбөрийн зорилгыг “Хүн амын дундах хепатитийн вирусийн халдварыг эрт илрүүлж, нарийвчилсан үзлэг, шинжилгээ, эмчилгээнд хамруулан, хяналтад авч, дархлаажуулах ажлыг зохион байгуулах замаар элэгний хатуурал, хорт хавдрын нас баралтыг бууруулна” гэж тодорхойлсон. Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах 3 зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

1. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж, дадлагажуулж, оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах.
2. Хепатитийн В, С вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, В вирусгүй иргэдийг дархлаажуулалтад хамруулах.
3. Хепатитийн В, С вирусийн архаг халдвартай хүнийг нарийвчилсан үзлэг, шинжилгээ, вирусийн эсрэг эмчилгээнд хамруулан, элэгний хатуурал, хорт хавдрын нас баралтыг бууруулах.

Хөтөлбөрийг I үе шат 2016-2018 он, II үе шат 2019-2020 он гэсэн хугацаа, үе шаттай хэрэгжүүлэхээр баталсан.

Дээрх тогтоолоор аймгийн Засаг даргад хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө баталж, уг ажлыг хариуцах, ажлын хэсэг томилж удирдлага, чиглэлээр хангаж ажиллахыг даалгажээ. Үүний дагуу 2016 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/580 тоот захирамжаар “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийн ажлын хэсэг, үйл

ажиллагааны төлөвлөгөөг баталжээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр 3 зорилт 15 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор аймгийн хөтөлбөр батлагдаад, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, ажлын хэсэг байгуулагдсаны дараа Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 112 тоот тогтоолоор “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг баталжээ. Үндэсний хөтөлбөр нь 2017-2020 онд хэрэгжиж, Монгол улсын хүн амын дунд гепатитийн вирусийн халдварын тархалтыг хязгаарлан, гепатитийн С вирусийн халдварын шинэ тохиолдлыг 2020 он гэхэд таслан зогсоож, гепатитийн вирусээс үүдэлтэй элэгний үрэвсэл, хатуурал, хорт хавдрын шалтгаант нас баралтыг эрс бууруулах гэж үндсэн зорилгыг тодорхойлсон байна. Үндэсний хөтөлбөрийг 2 үе шаттай 4 зорилтын хүрээнд үйл ажиллагааны 10 чиглэлээр 185 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Үндэсний хөтөлбөр, аймгийн хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжих хугацаа үндсэндээ давхардаж байгаа тул Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 03-ны А/250 тоот захирамжаар 2016 оны А/580 тоот захирамжийг хүчингүй болгож, “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлагаар хангах ажлын хэсэг, ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар шинэчлэн баталж, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан батлуулахыг ажлын хэсэгт даалгажээ.

Үүнээс хойш 2017, 2018 онд аймгийн хөтөлбөрийг үндэсний хөтөлбөртэй хамтатган хоёр удаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж, тэмдэглэл, тогтоолоор тодорхой үүрэг өгөгдөж байсан байна.

*1.2. “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийг Аймаг хөгжүүлэх хэтийн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан боловч 2018, 2019 оны аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаагүй байна.*

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хөтөлбөр баталсан тогтоолын Засаг даргад даалгах заалтад “Аймаг хөгжүүлэх хэтийн чиглэл, /2017-2024 он/, аймгийн Засаг даргын 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах, тоног төхөөрөмж, оношлуураар хангах асуудлыг тусгах” гэж заасан.

Аймаг хөгжүүлэх хэтийн чиглэл /2017-2024/ бодлогын баримт бичигт “Элэг бүтэн Монгол”, “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2016-2020 он/-д “Элэг бүтэн Төв аймагчууд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр тусгаж, үндэсний хөтөлбөрийн суурь түвшин батлагдсан бөгөөд орон нутгийн төсвөөс 216.3 сая төгрөг зарцуулах, хэрэгжилтийг 30-90 хувьд хүргэхээр төлөвлөжээ.

Жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан байдлыг үзэхэд

-2017 онд “Элэг бүтэн Төв аймагчууд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр тусгагдсан,

-2018, 2019 онуудад тусгагдаагүй,

-2020 онд “Элэг бүтэн-Монгол хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр баталжээ.

*1.3 Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь орон нутагт хэрэгжих боломжтой байна.*

Аймгийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийн ажлын хэсэг, үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/580 тоот захирамжаар ажлын хэсэг, арга хэмжээний төлөвлөгөө /2016-2020 он/ баталж, шаардлагатай төсвийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгуулах, “элэгний эмчилгээний зөвлөх төв” байгуулах үүрэг, чиглэл өгөгдсөн байна. Засгийн газрын тогтоолоор “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр батлагдсантай холбоотой аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 03-ны А/250 тоот захирамжаар “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, тус ажлын хэсэгт “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, батлуулахыг даалгажээ /энэ захирамжаар өмнөх 2016 оны А/580 тоот захирамжийг хүчингүй болгосон/. Гэвч ажлын хэсэг 2017, 2018 онуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна. “Элэг бүтэн Монгол”, “Элэг бүтэн Төв аймагчууд” үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө байхгүй тул хэрэгжих боломжтой зорилт арга хэмжээнүүд батлагдсан эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/448 тоот захирамжаар “Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2019-2020 он/-г үйл ажиллагааны 5 чиглэлээр 27 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталжээ.

Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд батлагдсан үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь орон нутагт хэрэгжих боломжтой байна.

**БҮЛЭГ 2. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, “Элэг бүтэн Төв аймагчууд” аймгийн хөтөлбөр хэрэгжсэнээр хүн амыг хепатитийн В,С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулах ажил хийгдэж тодорхой үр дүнд хүрсэн байна.**

*2.1. Хөтөлбөрийн хүрээнд илрүүлэг, оношилгоо, эмчилгээнд хамруулсан иргэдийн мэдээлэл, судалгаа, сан байхгүй хийгдсэн ажилд дүн шинжилгээ хийх боломжгүй байна.*

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн “Хепатитийн вирусийн халдварын өвчлөл, элэгний хорт хавдрын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ” гэсэн 4-р зорилтын 8-рт “Цахим программын ашиглалтад эрүүл мэндийн байгууллагын удирдлагаас байнгын хяналт тавьж, тайлан мэдээнд дүн шинжилгээ хийх” гэсэн арга хэмжээ тусгагдсан.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аймгийн төлөвлөгөөний /2019-2020 он/ 5 дугаар зорилтын 5.2-д “Цахим программын ашиглалтад эрүүл мэндийн байгууллагын удирдлагаас байнгын хяналт тавьж, тайлан мэдээнд дүн шинжилгээ хийх” гэсэн арга хэмжээ тусгагдсан.

Дээрх үндэсний хөтөлбөр болон аймгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргахдаа “2017-2018 оны 07 сар хүртэл Elegbuten.moh.mn сайтад иргэдийн мэдээллийг шивж оруулж байсан боловч 2018 оны 08 сарын 01-ээс health.gov.mn программд шилжсэн. Үүнтэй холбоотой илрүүлэг, оношилгоо, эмчилгээний мэдээлэл цахим программд шивэгдэж буй эсэхийг тогтмол хянаж, тайлан мэдээг 7

хоног бүрийн Баасан гаригт ЭМХТ-д мэдээлэн ажиллаж байсан. Гэвч 2019 онд ЭМГ-ын цахим программын эрхийг хаасан тул одоогоор нэвтрэн орж хянах боломжгүй болсон” гэж тайлагнажээ.

Эндээс үзэхэд аймгийн хэмжээнд хөтөлбөрийн хүрээнд хэчнээн хүнийг илрүүлэг, оношилгоо, эмчилгээнд хамруулсан гэсэн мэдээлэл, судалгаа, сан байхгүй хийгдсэн ажилд дүн шинжилгээ хийх боломжгүй болсон байна.

## *2.2. Хөтөлбөрийн хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, оношлуураар хангагдсан байна.*

Хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын 2016 оны А/580 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан 12 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсныг 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/250 дугаар захирамжаар хүчингүй болгож, тус захирамжаар аймгийн ЗДТГ-ын даргаар ахлуулан орлогч дарга, 2 нарийн бичгийн дарга, 13 гишүүд нийт 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн болон сумдын ЭМТ-ын эмч, мэргэжилтэн, ажилтнууд оролцож ажилласан байна.

Хөтөлбөр хэрэгжих явцад шаардлагатай оношлуур, тоног төхөөрөмжөөр хангах ажил хийгджээ. Аймгийн засаг даргын нөөц сангаас 2017 онд аймгийн Нэгдсэн эмнэлэгт элэгний В,С вирусийн ачаалал тоолох аппарат худалдан авч өгсөн, 2018-2020 онд 515 иргэний вирусийн ачаалал тоолох шинжилгээг энэ аппаратаар хийжээ.

2017 онд аймгийн Нэгдсэн эмнэлэг хариуцан тендер зарлаж 17000 ширхэг илрүүлэг шинжилгээний багц авсан. Мөн онд ЭМГ-ын төсвөөс 1600 ширхэг В, С вирусийн оношлуур худалдан авсан байна.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн яамнаас 2018 онд үнэ төлбөргүйгээр 50,287 ширхэг В, С вирусийн оношлуурыг хүлээн авчээ.

Ингэснээр 2017, 2018 онуудад нийт 68,887 ширхэг оношлуураар хангагдсан байна. Аймгийн хэмжээнд 15-с дээш насны 66,661 иргэн байгаа гэсэн судалгаа гаргасан бөгөөд тооцсон иргэдийг бүрэн хамруулах оношлуураар хангагдсан байна.

## *2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн байна.*

“Элэг бүтэн Төв аймагчууд хөтөлбөр” баталсан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 22 тоот тогтоолын аймгийн Засаг даргад даалгасан заалтын 2.3-д “Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2016 онд шаардлагатай хөрөнгийг боломжтой эх үүсвэрээс санхүүжүүлж, энэ оны төсвийн тодотголд тусгуулан батлуулах, цаашид шаардлагатай төсвийг жил бүрийн аймгийн нэгдсэн төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах” гэсэн заалт орсон.

Үндэсний болон аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр дараах байдлаар шийдвэрлэгдсэн байна.

-Аймгийн Засаг даргын 2017 оны А/309 тоот захирамжаар “Элэг бүтэн Монгол” Үндэсний хөтөлбөрийн нээлтийг Зуунмод суманд зохион байгуулагдах өдөрлөгт 4.97 сая төгрөг

- Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2017 онд элэгний В,С вирусийн ачаалал тоолох аппарат худалдан авахад Засаг даргын нөөц сангаас 55.0 сая төгрөг

- 2017 онд оношлуур худалдан авахад аймгийн Нэгдсэн эмнэлэг сумдын ЭМТ-ийн төсвөөс 25.9 сая төгрөг

- Аймгийн ЭМГ-н төсвөөс 2017 онд 2.1 сая төгрөг оношлуур авахад

- Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн яамнаас 2018 онд үнэ төлбөргүйгээр 41.9 сая төгрөгийн үнэ бүхий оношлуур ирсэн байна.

#### 2.4. Урьдчилан сэргийлэх, дархлаажуулах ажил хийгдэж байна.

Хөтөлбөрийг 2019-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 1 дүгээр чиглэлийг сургалт сурталчилгаа болон дархлаажуулалт гэх 2 дэд хэсэгт хувааж тус бүр 4 үйл ажиллагааг явуулахаар төлөвлөсөн байна.

Сургалт сурталчилгааны чиглэлээр:

- Хепатитийн вирусийн халдвараас сэргийлэх эрүүл зан үйлийг хэвшүүлэх арга хэмжээг олон хэлбэрээр зохион байгуулах
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд эрүүл мэндээ хамгаалах, зөв зан үйлийг хэвшүүлэх арга хэмжээг олон хэлбэрээр зохион байгуулах
- Эмч, эмнэлгийн ажилтан, элэгний хөтчүүдийг иргэдэд зөвлөгөө өгөх аргачлалд сургах, чадавхжуулах
- Хепатитийн В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтын ач холбогдол сэдвээр сурталчилгааг өргөжүүлэх зэрэг ажлыг хийхээр төлөвлөсөн байна.

Тус чиглэлээр 4 жилийн хугацаанд:

- Иргэд, аймгийн нэгдсэн эмнэлэг болон 27 сумын эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудад, цэцэрлэг, ЕБС-ийн сурагчид зэрэг нийт 16032 хүнд 18 удаагийн сургалт сурталчилгаа явуулсан
- Иргэдийг хепатитийн вирусийн халдвараас сэргийлэх эрүүл зан үйлийг төлөвшүүлэх талаар олон нийтийн мэдээллийн хэрэгсэл /фэйсбүүк хуудас/, Тbs телевиз-д бүрэн хэмжээний ярилцлага-3 удаа, мэдээлэл-3 удаа хийсэн. Мөн олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд гарын авлага, тараах материал тарааж сурталчилгаа мэдээллийг хүргэн ажиллаж байна.
- Мөн дэлхийн хепатитийн өдрөөр 150 хүнд элэгний В С вирусийн илрүүлэг шинжилгээг хийж, 10 төрлийн 473 ширхэг гарын авлага тараах материалыг тараасан байна.
- Мөн хепатитийн В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтын талаар мэдээлэл, сурталчилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон ДУС-н олон нийт, фэйсбүүк хуудас, телевиз зэргээр тогтмол явуулж байна гэж хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргасан байна.

Аудитад сургалт сурталчилгаа зохион байгуулсан талаар дараах баримтыг ирүүлсэн.

- 2017 оны 05 дугаар сард хепатитийн В вирусийн халдвараас сэргийлье сэдэвт сургалтад 32 дархлаажуулалтын сувилагч, албаны мэргэжилтэнг хамруулсан.
- 2017 оны 06 дугаар сард "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь" сэдэвт сургалтад 26 эмч эмнэлгийн ажилтнуудыг хамруулсан.
- 2018 оны 4 дүгээр сард "Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийн 2 дахь шатны нээлтийн арга хэмжээг Төв аймгийн Аргалант суманд зохион байгуулан 140 иргэнийг илрүүлэг шинжилгээнд хамруулсан.
- 2018 оны 7 дугаар сард хепатитийн вирусийн илрүүлэг шинжилгээ хийх арга зүйг эзэмшүүлэх сургалтыг 35 эмнэлгийн ажилтныг хамруулан зохион байгуулсан.

Дээрхээс бусад сургалт сурталчилгаа явуулж, иргэд олон нийтийг хамруулсан талаар баримтыг аудитад ирүүлээгүй.

Дархлаажуулалтын чиглэлээр:

1. Хепатитийн В вирусийн халдварын эсрэг төрсний дараах 24 цагийн доторх дархлаажуулалтыг тогтмолжуулах, вакцинаар тасралтгүй хангах
2. Хепатитийн А вирусийн эсрэг товллын дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх
3. Хепатитийн В вирусийн халдваргүй иргэдийг сайн дурын дархлаажуулалтад хамруулах
4. Эрүүл мэндийн байгууллага, онцгой байдал, цагдаагийн байгууллагын ажилтнуудыг хепатитийн В вирусийн эсрэг дархлаажуулалтад хамруулах талаар зөвлөмж хүргүүлж, хамтран ажиллах зэрэг ажлыг хийхээр төлөвлөсөн байна.

ЭМГ-аас гаргасан статистик мэдээлэлд хепатитийн В вирусийн эсрэг төрсний дараах 24 цагийн доторх дархлаажуулалтад хамрагдвал зохих 1030 нярайгаас 1021 нярай хамрагдсан хамрагдалтын хувь 99.13% гэж мэдээлсэн байна. Хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтэд 12 дугаар сарын байдлаар хамрагдвал зохих 1059 нярайгаас 1048 нярай хамрагдсан. Хамрагдалтын хувь: 98,96% гэж зөрүүтэй тайлагнасан байна.

Хепатитийн В вирусийн эсрэг төрсний дараах 24 цагийн доторх дархлаажуулалт

| № | Он   | Хөтөлбөрийн хэрэгжилт               |                            |                                  | ЭМГ-ын статистик мэдээ<br>/12 сарын байдлаар/ |                            |        |
|---|------|-------------------------------------|----------------------------|----------------------------------|-----------------------------------------------|----------------------------|--------|
|   |      | Хамрагдвал<br>зохих<br>хүүхдийн тоо | Хамрагдсан<br>хүүхдийн тоо | Хувь                             | Хамрагдвал<br>зохих<br>хүүхдийн тоо           | Хамрагдсан<br>хүүхдийн тоо | Хувь   |
| 1 | 2017 | 852 /10 сарын<br>байдлаар/          | 850 /10 сарын<br>байдлаар/ | 99.77%<br>/10 сарын<br>байдлаар/ | 1040                                          | 1038                       | 99.81% |
| 2 | 2018 | 1121                                | 1119                       | 99.82%                           | 1121                                          | 1119                       | 99.82% |
| 3 | 2019 | 1084                                | 1072                       | 98.89%                           | 1084                                          | 1072                       | 98.89% |
| 4 | 2020 | 1059                                | 1048                       | 98.96%                           | 1030                                          | 1021                       | 99.13% |

Эх сурвалж: Төв аймгийн эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл,  
2017-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилт

Мөн хепатитийн А вирусийн эсрэг товллын дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2020 оны 12 сарын байдлаар А хепатитийн эсрэг товллын дархлаажуулалтын 1 тунгийн хамрагдалт: 96,98%, 2 тунгийн хамрагдалт: 97,70% байна гэж, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдал, цагдаагийн байгууллагын ажилтнууд болон иргэдийг сайн дурын хепатитийн В вирусийн эсрэг дархлаажуулалтад хамруулах чиглэлээр нийт 3401 иргэнийг вакцинжуулсан гэж хэрэгжилтийг тайлагнасан боловч аудитын явцад холбогдох баримтыг ирүүлээгүй.

Хепатитийн В вирусийн халдваргүй иргэдийн вакцинжуулалт

| № | Он   | Дархлаажуулалт           |                               |                                            |
|---|------|--------------------------|-------------------------------|--------------------------------------------|
|   |      | Сайн дурын<br>хамрагдалт | ЭМ-ийн<br>салбарын<br>ажилтан | Бусад /цагдаа,<br>онцгой байдал гэх<br>мэт |
| 1 | 2017 | 1470                     | 774                           |                                            |
| 2 | 2018 | 431                      | 172                           |                                            |

|      |               |      |      |    |
|------|---------------|------|------|----|
| 3    | 2019-2020 онд | 188  | 300  | 66 |
| Нийт |               | 2089 | 1246 | 66 |

Эх сурвалж: 2017-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилт

*2.5. Халдварын эрт илрүүлэх шинжилгээнд иргэдийн хамруулах ажил төлөвлөсний дагуу хэрэгжсэн байна.*

“Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийн хүрээнд 30-аас дээш насны хүн амын 15.3 хувийг илрүүлэг шинжилгээнд хамруулжээ. 2017 онд үндэсний хөтөлбөр батлагдсанаар 40-65 насны хүн амыг илрүүлэг шинжилгээнд хамруулж, ЭМД-ын сангаас зардлыг хариуцах болсноор илрүүлэг шинжилгээнд хамрагдвал зохих 40-65 насны хүн амын 47.6 хувийг 2017 онд, 18.7 хувийг 2018 онд, 12.6 хувийг 2019 онд, 22.7 хувийг 2020 онд хамруулсан мэдээ, судалгааг аймгийн ЭМГ-аас гаргажээ.

Гэвч аймгийн ЭМД-ын хэлтсээс В,С вирусийн илрүүлэг шинжилгээнд хамрагдаж, даатгалын сангаас санхүүжилт авахаар ирүүлсэн нэхэмжлэхийн хүний тоо нь ЭМГ-ын илрүүлэг шинжилгээнд хамрагдалтын судалгааны нийт хүний тооноос 2.2 дахин бага байна. ЭМД-аас авсан санхүүжилтийн дүнгээс харахад илрүүлэг шинжилгээнд хамрагдалт 2017 онд 23 хувь, 2018 онд 24 хувь, 2019 онд 2 хувь, 2020 онд 0 хувьтай байна.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2019-2020 онд илрүүлэг шинжилгээнд хамрагдаагүй хүн амыг хепатитийн В,С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулах арга хэмжээний хүрээнд 2019 онд 40-65 насны иргэдийн 60 хувь, 15-39 насны иргэдийн 45 хувь, 2020 онд 40-65 насны иргэдийн 70 хувь, 15-39 насны иргэдийн 50 хувийг хамруулах зорилт тавьсан. Хөтөлбөр хэрэгжиж байх хугацаанд 2019 онд 15-39 насны 21842 иргэнийг хамруулсан нь 59.11 хувь 40-65 насны 18816 иргэнийг хамруулсан нь 75.27 хувь болж шалгуур буюу хүрэх түвшнийг хангасан байна.

*2.6. Элэгний С вирустэй иргэдийн 40 хувийг эмчилгээнд хамруулах зорилт тавьсан боловч 30.81 хувь нь эмчилгээнд хамрагдсан байна.*

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш элэгний С вирусийн илрүүлэгт 49055 хүн хамрагдаж 3070 хүнээс С вирус илрүүлсэн байна. Тухайлбал 2016 онд 4851 хүн хамрагдаж 365 хүнээс, 2017 онд 11901 хүн хамрагдаж 1295 хүнээс, 2018 онд 15165 хүн хамрагдаж 430 хүнээс, 2019 онд 11590 хүн хамрагдаж 596 хүнээс, 2020 онд 5548 хүн хамрагдаж, 384 хүнээс С вирус илэрсэн байна. 2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтэд С вирусийн эмчилгээнд 946 хүн буюу нийт халдвартай иргэдийн 31.25%-ийг хамруулсан гэж мэдээлсэн боловч нийт 3070 хүнээс 946 хүн буюу 30.81%-ийг эмчилгээнд хамруулсан байна.

Элэгний В вирусийн илрүүлэгт 49055 хүн хамрагдаж 2967 хүнээс В вирус илрүүлсэн байна. Тухайлбал 2016 онд 4851 хүн хамрагдаж 306 хүнээс, 2017 онд 11901 хүн хамрагдаж 839 хүнээс, 2018 онд 15165 хүн хамрагдаж 895 хүнээс, 2019 онд 11590 хүн хамрагдаж 614 хүнээс, 2020 онд 5548 хүн хамрагдаж, 313 хүнээс В вирус илэрсэн байна. 2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтэд В вирусийн эмчилгээнд 492 хүн буюу нийт халдвартай иргэдийн 17.02%-ийг хамруулсан гэж мэдээлсэн боловч нийт 2967 хүнээс 492 хүн буюу 16.58%-ийг эмчилгээнд хамруулсан байна.

Төв аймгийн ЭМГ-ын Эрүүл мэндийн сар тутмын мэдээллийн “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн үзлэгийн мэдээ хепатитийн вирусийн халдварын эрт илрүүлэг шинжилгээнд хамрагдсан хүний тоон мэдээллийг “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилттэй харьцуулахад 0.44%-иар зөрүүтэй байна.

*2.7. Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр гаргаж байгаа боловч элэгний хорт хавдар, хатуурлаар өвчлөгсдийн тоо болон нас баралтын талаарх тоон мэдээлэл тусгаагдаагүй байна.*

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн статистик хариуцсан мэргэжилтнээс ирүүлсэн тоо мэдээллээс үзэхэд хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнөх онд элэгний хорт хавдрын шинэ илрэл 75, нас баралт 60 бүртгэгдэж байсан бол 2020 онд элэгний хорт хавдрын шинэ илрэл, нас баралт тус бүр 6 тохиолдлоор буурсан байна.

| № | Он   | Элэгний хорт хавдар шинэ илрэл | Элэгний хорт хавдрын нас баралт |
|---|------|--------------------------------|---------------------------------|
| 1 | 2015 | 75                             | 60                              |
| 2 | 2016 | 83                             | 56                              |
| 3 | 2017 | 111                            | 71                              |
| 4 | 2018 | 86                             | 71                              |
| 5 | 2019 | 89                             | 77                              |
| 6 | 2020 | 69                             | 54                              |
|   | Нийт | 513                            | 389                             |

Эх сурвалж: Аймгийн нэгдсэн эмнэлгийн статистик мэдээлэл

*2.8. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагдсан зарим зорилт арга хэмжээ нь хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хангасан байна.*

Аймгийн Засаг даргын 2017 оны А/250 дугаар захимжаар “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, тус ажлын хэсэгт “хөтөлбөрийн хэрэгжилтэд сар бүр хяналт тавьж тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 30-ны дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх” гэсэн үүрэг өгөгдсөн байна. “Элэг бүтэн Төв аймагчууд” аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг 2017-2019 онуудад Засаг даргын зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж байсан боловч 2020 онд эцсийн байдлаар оруулаагүй байна.

Харин “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2017-2020 онуудад гаргасан байна.

2017 онд “Элэг бүтэн монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан гэж гаргасан ба хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлтийг 4 зорилтын дундаж 62.5 хувьтай гэж дүгнэжээ.

2018 онд Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгт гэсэн маягтаар хэрэгжилтийг гаргаж хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлтийг 4 зорилтын дундаж 70.0 хувьтай гэж дүгнэсэн байна.

2019 онд Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгт гэсэн маягтаар хэрэгжилтийг гаргаж хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлтийг хийгээгүй.

2020 онд “Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт гэсэн маягтаар гаргаж, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлтийг 4 зорилтын дундаж 76.25 хувьтай гэж дүгнэжээ.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг авч үзвэл дараах байдалтай байна.

Хепатитийн вирусийн халдвараас сэргийлэх мэдлэг олгох, эрсдэлт зан үйлийг өөрчлөх дадал хэвшилд сургах сургалт, сурталчилгааг өргөжүүлснээр 10000 хүнд ноогдох цочмог өвчлөлийг 0.22 промилиэс ихгүй байлгах гэсэн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.Сургалт сурталчилгааны чиглэлээр хэрэгжүүлсэн 5 арга хэмжээ хүрэх түвшин буюу шалгуур үзүүлэлтээ хангажээ.

2. Дархлаажуулалтын чиглэлээр 4 арга хэмжээ хэрэгжүүлснээс 3 арга хэмжээ хүрэх түвшин буюу шалгуур үзүүлэлтээ хангаж, гепатитийн В вирусийн халдваргүй иргэдийг сайн дурын дархлаажуулалтад 2019 онд 300 хүн, 2020 онд 600 хүн хамруулах гэсэн арга хэмжээний хүрээнд 188 иргэн хамрагдаж хүрэх түвшнийг хангаагүй байна.

1 дүгээр зорилтын гол үзүүлэлт 10000 хүнд ноогдох цочмог өвчлөлийг 0.22 промилиэс ихгүй байлгах гэсэн зорилт хэрэгжсэн эсэхийг тодорхой гаргаж тайлагнасан баримт бичиг байхгүй байна.

Хепатитийн вирусийн халдварын илрүүлэгт 15-аас дээш насны 10,000 хүнийг хамруулж, элэгний хатуурал, хорт хавдрын эрт илрүүлэгийг нэмэгдүүлэх гэсэн 2 дугаар зорилтын хүрээнд 5 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлжээ. Хүн амд хепатитийн илрүүлэг шинжилгээнд хамрагдахыг уриалсан уриалга гаргах, сурталчилгааг олон хэлбэрээр зохион байгуулах гэсэн арга хэмжээнд 2020 онд 2500 хүнийг хамруулж 5 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөснөөс 2 арга хэмжээ зохион байгуулсан, элэгний Д вирусийн халдвар илрүүлэх шинжилгээг эхлүүлэх гэсэн арга хэмжээ улсын хэмжээнд хэрэгжээгүй бусад 3 арга хэмжээ хэрэгжиж шалгуур буюу хүрэх түвшинг хангасан байна.

Хепатитийн вирусийн халдвартай иргэдийн 60%-г эмчилж эрүүлжүүлэх замаар элэгний хатуурал, хавдарт шилжих эрсдэлийг бууруулах гэсэн 3 дугаар зорилтын хүрээнд 4 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилт гаргасан баримт бичгүүдэд вирусийн халдвартай хэдэн хүн гарсан түүнээс хэдэн хүнийг буюу хэдэн хувийг эмчилгээнд хамруулсан талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.

Төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдэд хяналт шалгалт, хяналт үнэлгээ хийх гэсэн 4 дүгээр зорилтын хүрээнд 7 арга хэмжээг МХГ хариуцан, ЭМГ-тай хамтран хэрэгжүүлэхээр тусгасан боловч МХГ хариуцаж зохион байгуулсан ажил байхгүй, ЭМГ хяналт шалгалтын чиглэлээр хийсэн ажлаа тайлагнасан байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын оролцоог нэмэгдүүлэх гэсэн 5 дугаар зорилтын хүрээнд 3 арга хэмжээ төлөвлөжээ. Цахим программын ашиглалтад эрүүл мэндийн байгууллагын удирдлагаас байнгын хяналт тавьж, тайлан мэдээнд дүн шинжилгээ хийх гэсэн арга хэмжээний хүрээнд тодорхой ажил хийгдэж байсан боловч 2019 онд ЭМГ-ын цахим программын эрхийг хаасан тул одоогоор нэвтрэн орж хянах боломжгүй болсон байна.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилго нь “Хүн амын дунд хепатитийн вирусийн халдварын тархалтыг хязгаарлан, хепатитийн С вирусийн халдварын шинэ тохиолдлыг 2020 он гэхэд таслан зогсоож, хепатитийн вирусээс үүдэлтэй элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулах”, “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийн үндсэн зорилго нь “Хүн амын дундах хепатитийн вирусийн халдварыг эрт илрүүлж, нарийвчилсан үзлэг, шинжилгээ, эмчилгээнд хамруулан, хяналтад авч, дархлаажуулах ажлыг зохион байгуулах замаар элэгний хатуурал, хорт хавдрын нас баралтыг бууруулах” гэж тус тус тодорхойлсон. Үндэсний болон аймгийн хөтөлбөрүүд 2020 онд хэрэгжиж дууссан хэдий ч хөтөлбөрийн хэрэгжилтийг эцсийн байдлаар гаргаж үр дүнг тооцож, Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэх ажил хийгдээгүй байна.

*БҮЛЭГ 3. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, “Элэг бүтэн Төв аймагчууд” аймгийн хөтөлбөр нь 2017-2020 онд хэрэгжиж дууссан, хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж үнэлэлт, дүгнэлт өгөх ажил хийгдээгүй байна*

### *3.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг ИТХ-н Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажилласан байна.*

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хэлэлцээд аймгийн Засаг даргад тэмдэглэлээр 6 үүрэг өгөгдсөн, 2018 оны 11 дүгээр сарын 13-нд “Элэг бүтэн Монгол”, “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцыг хэлэлцээд “Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 97 тоот тогтоолоор Засаг даргад 4 үүрэг өгөгдсөн байна.

Мөн 2017 он, 2018 он, 2019 онуудад Засаг даргын зөвлөлийн хурлаар хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцүүлж ажилласан байна.

Аймгийн Засаг дарга болон сумдын засаг даргын хооронд 2019 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд “Элэг бүтэн төв аймагчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, зорилтот насны иргэдийг эрт илрүүлэг үзлэгт бүрэн хамруулах, хепатитийн в, с вирус илэрсэн иргэдийг вирусийн эсрэг эмчилгээнд хамруулах” шалгуур үзүүлэлтийг тусган оруулж сум тус бүрээр суурь түвшинг хүрэх түвшинтэй нь гаргаж хэрэгжилтийг дүгнэжээ.

Хөтөлбөр хэрэгжих хугацаанд аймгийн засаг даргын нэрэмжит үзлэгийн сум дүгнэх 23 шалгуурын 16-д “элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан ажлын үр дүн ахиц, 17-д “элэг бүтэн төв аймагчууд” хөтөлбөрийн эрт илрүүлэг, хяналтын хувь гэсэн шалгуураар үзүүлэлтээр үнэлж дүгнэсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/393 дугаар тушаалаар “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж буй байгууллага, даатгуулагчдад үзүүлж байгаа тусламж үйлчилгээний чанар, ЭМД-с олгох санхүүжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, шалгалт хийх ажлын хэсэг, ажлын хэсгийн удирдамжийг баталсан байна. Энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжид 6 байгууллагад 2018 оны 10 дугаар сарын 1-20 өдрүүдэд ажиллана гэсэн дотор Төв аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төв гэж орсон. Аймгийн ЭМГ-т энэ шалгалттай холбоотой ямар нэг баримт бичиг байхгүй, шалгалт хийгдсэн эсэх, хийгдсэн бол илэрсэн асуудал, засаж сайжруулах талаар ямар үүрэг өгөгдсөн болон түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар баримт материал байхгүй байна.

“Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийн 2019-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний “Төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдэд хяналт шалгалт, хяналт үнэлгээ хийх” гэсэн үйл ажиллагааны 4-р чиглэлийн хүрээнд аймгийн МХГ хариуцаж 7 арга хэмжээ хэрэгжүүлж ажиллахаар тусгагдсан боловч нэг ч арга хэмжээ хэрэгжүүлээгүй байна.

### *3.2. Хөтөлбөр хэрэгжсэн дөрвөн жилийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.*

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн 6.1-т “Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг бүх шатны Засаг дарга Эрүүл мэндийн салбар зөвлөлтэй хамтран өвчтөн, нийгмийн төлөөллийг оролцуулан гүйцэтгэж, тайлангаа эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор хүргүүлнэ” гэж заасан. Аймгийн ЭМГ хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр гаргаж, хяналт-шинжилгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

Харин аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-с хөтөлбөр хэрэгжсэн 4 жилийн хугацаанд үндэсний болон аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж байгаагүй байна.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, “Элэг бүтэн Төв аймагчууд” аймгийн хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд аймгийн хэмжээнд элэгний В,С вирусийн илрүүлэг шинжилгээнд хамрагдвал зохих 15-аас дээш насны 66661 иргэнээс 48560 буюу 72.84 хувийг хамруулсан нь үндэсний болон аймгийн хөтөлбөрийн шалгуурыг хангасан байна.

Илрүүлэг шинжилгээгээр 5340 иргэнээс вирусийн халдвар илэрснээс 59 хувь буюу 3126 иргэн идэвхжил тодорхойлуулсан. Вирусийн эмчилгээнд 1299 иргэн хамрагдаж, эмчилгээний амжилт 98,72 хувьтай байна. Вирусийн эсрэг дархлаажуулалтад давхардсан тоогоор 3431 иргэн хамруулж, В вирусийн эсрэг вакцины хамрагдалт 99,82 хувь, А вирусийн эсрэг вакцины 2-р тунгийн хамрагдалт 99,64 хувь байгаа нь Халдварт өвчин судлалын үндэсний төвийн шалгуурыг хангасан. Хөтөлбөр 73.1 хувьтай хэрэгжсэн байна.

## ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Зайлшгүй хэрэгцээ шаардлагад үндэслэж “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөр боловсруулагдаж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлагдсан байна.
- Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2017, 2018 онуудад боловсруулж батлуулаагүй захирамжаар өгөгдсөн үүргийг хэрэгжүүлээгүй байна
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, оношлуураар хангагдсан байна.
- Халдварын эрт илрүүлэх шинжилгээнд иргэдийг хамруулах ажил төлөвлөсний дагуу хэрэгжсэн байна.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хөндлөнгийн ямар нэг хяналт тавигдаж байгаагүй байна
- Хүн амын дунд гепатитийн вирусийн халдварын тархалтыг хязгаарлан, гепатитийн С вирусийн халдварын шинэ тохиолдлыг 2020 он гэхэд таслан зогсоож, гепатитийн вирусээс үүдэлтэй элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулах гэсэн “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилго, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 10000 хүнд ноогдох цочмог өвчлөлийг 0.22 промилиэс ихгүй байлгах, гепатитийн вирусийн халдвартай иргэдийн 60 хувийг эмчилж эрүүлжүүлэх замаар элэгний хатуурал, хавдарт шилжих эрсдэлийг бууруулах гэсэн зорилтууд хэрхэн хэрэгжсэн нь тодорхойгүй байна.
- “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, “Элэг бүтэн Төв аймагчууд” аймгийн хөтөлбөр нь 2017-2020 онд хэрэгжиж дууссан боловч хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж үнэлэлт, дүгнэлт өгөх ажил хийгдээгүй байна.

### ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарт зөвлөх нь:

- “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, “Элэг бүтэн Төв аймагчууд” аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн үнэлэлт, дүгнэлт өгч ажиллах

Аймгийн ЭМГ-ын дарга С.Мөнхтуяад зөвлөх нь:

- “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, “Элэг бүтэн Төв аймагчууд” аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, холбогдох байгууллагаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх
- “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, “Элэг бүтэн Төв аймагчууд” аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй холбоотой баримт, материалыг албажуулж архивын нэгж үүсгэх

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор

Ц.Хишигжаргал

Аудитын менежер

О.Амаржаргал

Тайлан бичсэн:

Ахлах аудитор

Л.Жаргалсайхан

Аудитор

Ч.Загдсүрэн

Аудитор

Г.Сугармаа

## Холбогдох байгууллагын санал:



### ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

41111, Төв аймаг, Зүүнмал сум, 1 дүгээр баг,  
Зүүнмал сумын газраар, Утас/Факс: 7027-3705  
Вэбсайт: www.ereg.to.gov.mn

2021.07.09 № 4/441  
тэнгэй -ны № -т

### ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөр”-ийн  
хэрэгжилтийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн  
төсөлтэй танилцсан нь үнэн болно.

Санал хүсэлт байхгүй тул холбогдох  
зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллахаа үүгээр  
уламжилж байна.

ДАРГА  С.МӨНХТҮЯА  
41111-0705107 7027-3705

4109 41077

My doc - 2021 on foot A-3

